



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар A/16

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны “Дүгнэлт хүргүүлэх тухай” 1-1/3881 тоот албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын “Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай” А/448, А/268 дугаар хамтарсан тушаалыг хуульд нийцүүлэн дахин баталж, хянуулж бүртгүүлэхээр ирүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлт ирүүлсэн тул Эрүүл мэндийн сайдын 2013 оны 207 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон сургуулийн дотуур байранд хамрагдаж буй хүүхдэд хоногт авбал зохих хүнсний бүтээгдэхүүн, үндсэн шимт бодис ба илчлэгийн хэмжээ” болон гуравдугаар хавсралтаар батлагдсан “Тусгай хоолны дэглэмтэй хүн, цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан хоол үйлчилгээнд хориглох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалт”-ыг тус тус сэргээн мөрдсүгэй.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/282 дугаар тушаалыг хүчингүйд тооцугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ